

**Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2023 оны
05 дугаар сард хийсэн ажлын товч мэдээ**

2023 оны 5 дугаар сарын 25

Дархан-Уул аймаг

Тус алба 5 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж, хяналт шалгалт хийхэд хүний нөөцийн дутагдалтай ажиллаж байна. Дотоод аудиторын 3 сул орон тоонд Төрийн албаны зөвлөлийн Дархан-Уул аймаг дахь салбар зөвлөлөөс тусгай шалгалт зарлахад 1 иргэн тэнцсэн ба дахин 2 дотоод аудиторын албан тушаалд төрийн жинхэнэ албан хаагчийг шилжүүлэх, сэлгэн ажиллуулах зарыг албаны цахим хуудас болон фэйсбүүк хуудсаар түгээж байна.

“Зулзагын голын ойжуулалтын төсөл”-ийн явцад төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг ажлын 5 хоногт хийж, тэмдэглэлийг Дархан-Уул аймгийн Засаг дарга, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Домогт Шарын гол ХХКомпанид тус тус хүргүүлсэн. Шалгалтаар 6 санал, зөвлөмжийг өгсөн.

Дархан-уул аймгийн Музейн үйл ажиллагаа болон Төсвийн ерөнхийлөн захирагчийн харъяа байгууллагуудад Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 2023 оны 1-р улирлын мэдээлсэн байдалд тус тус дотоод аудитыг ажлын 14 хоногт хийж, тайланг аймгийн Музей болон аймгийн Засаг дарга, Сангийн яамны СХЭУГ-т тус тус хүргүүлсэн. Дотоод аудитаар Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх мэдээллийн хугацаа хоцроосон 9 байгууллагад Зөвлөмж, аймгийн Музейн илэрсэн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, зөрчил арилгуулах тухай Улсын ахлах байцаагчийн 1 албан шаардлага хүргүүллээ.

Хонгор сумын Эрүүл мэндийн төв, Орхон сумын Эрүүл мэндийн төвд төлөвлөгөөт санхүүгийн хяналт шалгалт, Үйлдвэрлэл технологийн парк ОНӨААТҮГ-т дотоод аудитыг ажлын 14-20 хоногт тус тус хийж тэмдэглэл, ажлын баримтыг бичиж байна. Мөн Нэгдсэн эмнэлэгт ажлын 25 хоногт багтаан хийхээр 2023 оны 05 сарын 22-ны өдрөөс эхлэн төлөвлөгөөт санхүүгийн хяналт шалгалтыг эхлүүлээд байна.

Тус албанд ирүүлсэн хугацаатай мэдээ тайланг холбогдох газарт нь хугацаанд хүргүүллээ. Үүнд:

- Улсын төсвөөс санхүүжилт авдаг хувийн хэвшлийн болон сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудад Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангуулахад анхаарч ажиллах тухай албан бичгийг Боловсрол шинжлэх ухааны газарт хүргүүлсэн.

- Дархан-Уул аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хэлтсээс зохион байгуулж буй “Алсын хараа 2050”, Шинэ сэргэлтийн бодлого-ыг хэрэгжүүлэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор тус албаны 3 албан хаагч, 8 иргэнийг сургалтад хамруулах судалгааг цахимаар хүргүүлсэн.

- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн 2023 оны 1 дүгээр улирлын дотоод аудитын тайланг 2023.05.10-ны өдрийн 45 тоот албан бичгээр Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн.



- 2023.05.08-ны өдөр зохион байгуулагдсан боловсролын салбарын нягтлан бодогч нарын нэгдсэн уулзалт, сургалтад албаны Дотоод аудитор “Шилэн дансны хуулийн хэрэгжилт, шинэчилсэн цахим хуудас” сэдвээр сургалт, мэдээлэл хүргэлээ.

- Албаны бүтэц, орон тоо, эрх зүйн үндэслэл, чиг үүргийн талаарх мэдээллийг гаргаж ХЭЗХ-т цахимаар хүргүүлсэн.

- Дотоод аудиторын сул орон тооны сонгон шалгаруулалтад тэнцсэн албан хаагчийн ХАСУМ-ийг 2023 оны 05.15-ны өдрийн 47 дугаар албан бичгээр Авлигатай тэмцэх газарт хүргүүлж, хянуулан хариуг хүлээн авлаа.

- “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт, үнэлгээ хийх журам”-ын дагуу өөрийн байгууллагын үнэлгээг хийж аймгийн Засаг даргын Тамгын газарт албан бичгээр болон цахимаар хугацаанд нь хүргүүлсэн.

Албан хаагчид дараах сургалт, хэлэлцүүлэгт хамрагдлаа. Үүнд:

- "Төрийн алба-шинэтгэл" арга хэмжээний хүрээнд аймгийн төрийн захиргааны байгууллагуудын албан хаагчдыг мэргэшүүлэх арга зүйн цуврал сургалтуудын “Харилцааны тухай ойлголт” сэдэвт сургалтад 5 албан хаагч хамрагдлаа.



- Удирдлагын академиас зохион байгуулсан төрийн албан хаагчид зориулсан “Ёс зүй” сургалтад 5 албан хаагч хамрагдаж сертификат авсан.



- Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулж буй 7:4:10 “Зөөлөн менежмент” сэдэвт сургалтад 5 албан хаагч хамрагдсан.

- Аймгийн Төв номын сангаас зохион байгуулсан “Үндэсний бичиг үсгийн өдөр 2023” арга хэмжээний хүрээнд зохион байгуулсан хос бичигтэн цахим бичвэр болон түргэн уншлагын уралдаанд 4 албан хаагч оролцсон.



- Аймгийн удирдах ажилтны хурал, Санхүүгийн зохицуулах хороо болон Дархан-Уул аймгийн ЗДТГ-ын СТСХэлтсээс хамтран зохион байгуулсан “Санхүүгийн зах зээлийн мэдээлэл өгөх” нээлттэй өдөрлөг, “Боловсролын судалгаа арга зүйн чадвар төв” АЗДТГазартай хамтран аймгийн хэлтэс, агентлагийн удирдлагууд болон боловсролын байгууллагын захирал, эрхлэгч нарт зориулсан “Эерэг хандлага-Аз жаргалтай амьдрал” сэдэвт сургалтад албаны дарга, ЗГХЭГ-аас цахимаар зохион байгуулсан "Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн үнэлгээний журам"-ын төслийг танилцуулах, санал солилцох хэлэлцүүлэгт албаны 5 албан хаагч тус тус хамрагдсан.

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБА